



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн Өргөдлийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Хилийн боомтын тухай хуулийн хэрэгжилт, тулгамдсан асуудлаар ирүүлсэн өргөдлийн дагуу Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогтын мэдээллийг сонссонтой холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т чиглэл болгосугай:

1/Хилийн боомтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэн яаралтай боловсруулж Улсын Их Хурлын 2015 оны хаврын чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх, хуулийн төслийг боловсруулахдаа хилийн боомтод аюулгүй байдлыг хангах болон хяналтын чиг үүрэг хэрэгжүүлж байгаа байгууллагуудын санал, тооцоо, судалгаа, бодит шаардлагыг үндэслэх, хилийн боомтын шалгах нэвтрүүлэх чиг үүргийг Хил хамгаалах ерөнхий газарт буцаан шилжүүлэх асуудлыг тусгах.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

О.БААСАНХҮҮ

